

## МОНГОЛ ХЭЛНИЙ НЭГДМЭЛ АГУУЛГЫН ХИЧЭЭЛИЙН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН СЭДЭВ

### Хувилбар А

Хугацаа 60 минут  
оноо

Нийт 20

**Нэг. Эхийг анхааралтай уншаад даалгаврыг гүйцэтгээрэй.**

#### Нөхрийн тус

Нэг хүн морь, илжиг хоёрт ачаа ачаад аянд явжээ. Нэгэн өдөр илжиг нь мориндоо хэлжээ.

-Миний ачаа хүнддээд бие минь ядарч байна. Чи миний ачаанаас аваач гэж гуйв. Морь зөвшөөрсөнгүй. Илжиг хэсэг хугацааны дараа бүр явж чадахаа байлаа. Эзэн уурлан бүх ачааг моринд ачаад илжгийг орхиод явжээ. Морь цааш явахдаа цуцан:

-Илжгийг гуйхад л тусалдаг байж дээ. Тэгсэн бол ганцаараа ийм их ачаа үүрч явахгүй л байсан даа.

Нөхрийн тусыг бүтээвэл өөрийн тус ирнэ гэдэг би ч муухай зүйл хийж дээ гэж бодоод илжиг арайхийж явав.

**1. Эхэд юуны тухай өгүүлснийг бичээрэй./2 оноо/**

.....  
.....  
.....  
.....

**2. Дараах өгүүлбэрийн цөм бүтцийг олж, тодорхойлно уу? /2 оноо/**

Чи миний ачаанаас аваарай.

.....  
.....  
.....

**3. Эзэн уурлан бүх ачааг моринд ачаад илжгийг орхиод явжээ.**

Өмнөх өгүүлбэрээс жинхэнэ нэр 4-ийг олж бичээрэй. /2 оноо/

.....


**4. “Морь” гэсэн үгийг тийн ялгалын бүх нөхцөлөөр хувилгаж бичээрэй. /2 оноо/**

.....  
.....  
.....  
.....

5. Цэвэр+л гэсэн үгийн зөв холбож бичээд, дүрмийг тайлбарлаарай. /2 оноо/

.....  
.....  
.....

6. Үндэсний бичгээр бичсэн дараах сургаалыг уншаад кириллээр хөрвүүлж бичээрэй. /5 оноо/



.....  
.....  
.....  
.....  
.....

7. Уран зохиолын хичээл дээр үзсэн зохиолоосоо 1-ийг сонгоод өөрт төрсөн мэдрэмж, сэтгэгдлээ бичээрэй. Үгийн тоо 30-40 /5 оноо/

.....  
.....  
.....  
.....  
.....  
.....  
.....  
.....  
.....  
.....

**АМЖИЛТ ХҮСЬЕ.**

## МОНГОЛ ХЭЛНИЙ НЭГДМЭЛ АГУУЛГЫН ХИЧЭЭЛИЙН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН СЭДЭВ

### Хувилбар Б

Хугацаа 60 минут  
оноо

Нийт 20

Эхийг анхааралтай уншаад даалгаврыг гүйцэтгээрэй.

### Арслан оготно хоёр

Араатны хаан арслан ан хийж байгаад ихэд ядарсан тул үүрэндээ ирээд унтжээ. Тэгтэл нэг жижигхэн оготно дээгүүр доогуур нь гүйгээд унтуулсангүй. Арслан сэрээд оготныг бариад авав гэнэ. Уурандаа оготныг базаж алахыг даваан дээр оготно өршөөл эрэн гуйж:

- Намайг битгий хороогооч. Магадгүй би чамд тус болох ч юм бил үү гэв. Арслан оготны үгийг сонсоод инээд нь хүрч:
- Чи ийм жижигхэн байж надад яаж туслах вэ? гэхдээ яахав чамайг амьд үлдээе гэв.

Хүнд тус хийвэл өөрт тус ирнэ гэдэг хэзээ нэгэн цагт арсанд оготно туслах байх даа.

#### 1. Эхэд юуны тухай өгүүлснийг бичээрэй. /2 оноо/

.....  
.....  
.....  
.....

#### 2. Дараах өгүүлбэрийн цөм бүтцийг олж бичээд, тодорхойлно уу? /2 оноо/

Арслан оготны үгийг сонсов.

.....  
.....  
.....  
.....

#### 3. Араатны хаан арслан ан хийж байгаад ихэд ядарсан тул үүрэндээ ирээд унтжээ. Өмнөх өгүүлбэрээс жинхэнэ нэр 4-ийг олж бичээрэй. /2 оноо/

.....  
.....

**4. “араатан” гэсэн үгийг тийн ялгалын бүх нөхцөлөөр хувилгаж бичээрэй. /2 оноо/**

.....  
.....  
.....

**5. тус+л гэсэн үгийг зөв холбож бичээд, дүрмийг нь тайлбарлаарай. /2 оноо/**

.....  
.....  
.....  
.....  
.....

*Дорнод аймгийн Хөлөнбуйр сумын ерөнхий боловсролын сургууль*